



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/52

Модот

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Усны тухай хууль”ийн 13 дугаар зүйлийн 13,1,5 дахь заалт, Хэнтий аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 483 тоот дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Баянмод багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Өндөрхаан илч” ХХК-д аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын 2025 оны 483 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн ашиглах усыг сумын төвийн төвлөрсөн усны байгууламжаас автомашинаар тээвэрлэж дулаан үйлдвэрлэл болон ажилчдын унд ахуйн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгосугай.

2.Ус ашиглагчтай гэрээ байгуулаж, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Байгаль хамгаалагч (Ж.Тодбилэг)-т үүрэг болгосугай.

3.Ус ашиглах үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажиллаж ус ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлүүлэхийг татварын улсын байцаагч (П.Ганцэцэг), байгаль хамгаалагч (Ж.Тодбилэг)-т нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ



